

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2020 ОНЫ 05 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|----|--|---|-------------------|
| 1. | 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1 | Паркийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл Барилга хөгжлийн төвд магадлангаар хянаадан баталгаажсан. Зураг төслийн төсвийг Барилга хөгжлийн төвийн техникийн хурлаар хэлэлцүүлж нэгдсэн дүгнэлт гаргуулахаар бэлтгэж байна. | 100% |
| 2. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | БҮТП-ийн Газрын дарга нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэн БХБЯ, БХТ, ЭХЯ, Диспетчерийн үндэсний төвтэй уулзалт зохион байгуулан техникийн нөхцөлд тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХХ-ийн зөвлөсний дагуу Багануур 220/110/35 кв-ын дэд станцийн 110 кв-ын талаас хангуулахаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аар цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог гүйцэтгүүлэн 2020.05.27-нд хүлээн авсан. Мөн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХХ-ийн Зүүн Өмнөд бүсийн салбарын холбогдох инженер техникийн ажилтнуудтай уулзалт хийж цахилгаан хангамжийн холболтын схем болон хэрэглээ ачаалалын гаргалгааг зөвшилцв. | 100% |
| 3. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж | Паркийн Үйлдвэрийн албан kontорын барилгын гадна болон дотор инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулагдаж, дүүргийн хангагч байгууллагуудтай зөвшилцэн магадлалаар хянаадан баталгаажсан. Зураг төслийн төсвийг эцэслэн боловсруулан төсвийн экспертэд хянуулсан. Экспертийн өгсөн заавар зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлтийг тусган батлуулж, нэгдсэн дүгнэлт гаргуулахаар бэлтгэж байна. | 100% |
| 4. | БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө | БҮТП-ийн 2017-2020 оны стратеги төлөвлөгөө, “CROSS SWOT” шинжилгээнд дүгнэлт хийж, 2021-2024 оны II дунд хугацааны төлөвлөлтийг боловсруулсан. | 100% |
| 5. | 3Г-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хоёрдугаар бүлгийн төслийг боловсруулж байна. | | 100% |
| 6. | Гүйцэтгэлийн зорилт 1.3.2 | Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдаар компост бордоо хийх үзүүлэх сургалтыг үргэлжлүүлэх ажлын хүрээнд үйлдвэрлэл, технологийн албаны инженер мэргэжилтнүүд 6 айл өрхүүдийн компост бордоо хийсэн туршилтыг газар дээр нь үзэж танилцан, зөвлөгөө өгч ажилласан. | 100% |
| 7. | Гүйцэтгэлийн зорилт 3.2.4.1 | ХХААЯ, БСШУЯ, БОАЖЯ-уудтай паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр хамтран ажиллах саналын төслийг боловсруулж байна. | 70% |

| | | | |
|-----|---|--|------|
| 8. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар хариутай 7, хариугүй 15 бичиг нийт 22 албан бичиг ирсэн ба хариутай бичгийн шийдвэрлэлт, хариугүй бичгийн хаалт тус бүр 100 хувьтай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 19 хариугүй бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. | 100% |
| 9. | 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1 | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт болон Нийслэлийн Засаг даргын А/108, А/168 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс цаг үеийн холбогдох мэдээллийг байгууллагын baganuur-itp.mn цахим хуудсанд тасралтгүй байршуулан ажиллаж байна. | 100% |
| 10. | Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль | Мэдээллийн агуулга, стандартын дагуу шилэн дансыг хөтлөн байгууллагын цахим хуудсанд байршуулсан ба nyaгтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад үүрэгт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. | 100% |

НЭМЭЛТ АЖИЛ

| | | |
|-----|--|------|
| 11. | Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гарагт zendmaa@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 12. | Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног бүр гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 13. | НЗД-ын А/191 дүгээр захирамж, НЗДТГ-аас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Онцгой комисстoy хамтран ажиллаж, баталсан хуваарийн дагуу явган эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг боловсруулан нэгтгэж, орой бүр 21:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабт ubhealth2020@gmail.com цахим хаягаар, дүүргийн Онцгой комисст утсаар тайлagnan ажиллаж байна. Мөн эргүүлийн 7 хоногийн нэгтгэсэн тоон мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоног бүрийн баасан гарагт battsoojubcity@gmail.com цахим хаягаар хүргүүлж байна. | 100% |
| 14. | Паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер Б. Мөнгөнхуяг нь Ургамал нано-биотехнологийн, хүнд болон хүнсний үйлдвэрлэлийн бүсийн төлөвлөлтийг Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөлт, 3D хэмжээст байгуулалт хийж, бус тус бүрийн анимэйшн танилцуулгыг мэргэжлийн программ ашиглан гүйцэтгэсэн. | 100% |
| 15. | Улаанбаатар хотын Ерөнхий менежериийн 2020 оны А/01 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 2018 оны А/194 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ногоон бүсийн их цэвэрлэгээнд Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХХК, Холбооны болон Шуудан үйлчилгээний газруудтай хамтран батлагдсан хуваарьт газрын үүсмэл хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг 2020 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулан цуглуулсан хог хаягдлыг төв хогийн цэгт буулган ажилласан. Мөн тайланг дүүргийн ЗАА-ны цахим хаягт хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. | 100% |
| 16. | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд 5 хүртэлх тооны танин мэдэхийн бэлэг бэлдэж, 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст хүлээлгэн өгсөн. | 100% |

| | | |
|-----|--|------|
| 17. | Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтада зүүцгээ” аяны удирдамжийн дагуу холбогдох үйл ажиллагааг зохион байгуулсан тайланг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э. Оргилцогцлохын цахим хаягт хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 100% |
|-----|--|------|

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Lamurit

Б. НОМИНЗУЛ